



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 1/28

Чингис хот

Урьдчилан сэргийлэх арга хэмжээг
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр тушаал, аймгийн Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн №06 хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусийн болзошгүй халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах зорилгоор шуурхай штабыг сумдын Засаг даргын Тамгын газар, Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төвүүдэд байгуулж, халдвар бүртгэгдсэн тохиолдолд хорио цээрийн дэглэмийг тогтоож, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг сумдын Онцгой комисс болон холбогдох байгууллагын дарга нарт

2. Шашин номын хурал цуглаан, зан үйл болон олон нийтийг хамарсан уулзалт, сургалт семинар, урлаг соёл, спортын арга хэмжээг зохион байгуулахгүй байж иргэдэд мэдээ мэдээллийг хүргэж ажиллахыг Боловсрол соёл урлагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, сумдын Засаг дарга нарт

3. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэлгүй байхыг онцгойлон анхаарч Цагаан сарын баяртай холбогдуулан хүнс, барааны үзэсгэлэн худалдаа, зар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээхгүй байхыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын дарга эрхлэгч болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газруудад

4. Хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж байгаа зорчигчдын эрүүл мэндийн байдалд хяналт тавих, тээврийн хэрэгсэлд халдваргүйтгэл хийж ажиллахыг Авто тээврийн төв, Онцгой байдлын газар, Зооноз өвчин судлалын төв, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газруудад тус тус үүрэг болгосугай.

5. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоолын дагуу аймаг, сумдын Онцгой комисс, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Авто

231010227

тээврийн төв, Мэргэжлийн хяналтын газруудыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт, бусад аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагааг 2 цаг хүртэл хугацаагаар богиносгож шаардлагатай үед тусгай горимд шилжин ажиллахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт

6. Томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 0-5 хүртэлх насны хүүхэд болон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асарч байгаа эх, эцэг, асран хамгаалагчид 5 хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгохыг аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт

7. Шуурхай штаб, мэргэжлийн байгууллагаас гаргасан албан ёсны мэдээ мэдээлэл, COVID-2019 халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж анхааруулгыг бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүн амд түргэн шуурхай, хүртээмжтэй байдлаар хүргэж ажиллахыг Сурталчилгааны албаны дарга С.Ган-Эрдэнэ, Мэдээлэл холбоо сүлжээ ХК-ны дарга О.Од-Эрдэнэ нарт

8. Архи согтууруулах ундаа түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж байгууллагууд 18:00 цагаас хойш архи согтууруулах ундааг худалдан борлуулахгүй байх, түүнд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газарт

9. Сумдын Онцгой комисс, Гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн анги, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдүүд гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, хүч хэрэгслийг томилгоожуулж, бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллаж авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 7 хоног бүрийн Даваа гаригийн 14:00 цагт шуурхай штабт танилцуулж ажиллахыг аймаг, сумдын Онцгой комисс, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, орон тооны бус штабын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг шуурхай штабын дарга, дэд хурандаа Н.Чанцалд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА